

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5	Хавсралт.....	24
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	24

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ,  
ДЭД ХУРАНДАА Л.БАТТӨР ТАНАА

2019.02.25 № 06/277  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус эмнэлэгийн захирал Л.Баттөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн бараа материал, орлого, зардлын бүртгэл, гэрээ ажил үйлчилгээг хууль журамд нийцүүлэх тухай зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 14-нөөс 2019 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 104 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Шударга өрсөлдөөн, сонголтонд суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх явдал мөн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

2018 онд 8 стратегийн хүрээнд 36 зорилт дэвшүүлэн 175 арга хэмжээ төлөвлөж ажилласнаас 99.4 хувийн биелэлттэй хэрэгжүүлж ажилласан байна. Үүнээс дурдвал:

- 2018 онд стационарийн хэсэг ашиглалтанд орж, эмнэлгийн үйл ажиллагааг бүрэн хүчин чадлаар явуулахтай холбогдуулан, эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог шинэчлэн батлуулах төслийг боловсруулан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/02 дугаар тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна. 2017 онд 233 орон тоотой байснаас 2018 онд 355 орон тоотой болж нэмэгдсэн байна.

- Австрийн 7.0 сая еврогийн төслийг амжилттай хэрэгжүүлж, 87 төрлийн 181 ширхэг техник, тоног төхөөрөмжүүдийг угсран үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн ажиллажээ. Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн хийн системээр бүрэн хангагдсан, ламинар урсгал бүхий вакум мэс заслын 6 өрөө, орчин үеийн мэс заслын өрөөний зөөврийн рентген C-arm аппарат, ариутгал, угаалгын нэгдсэн төв зэргийг бүтээн байгуулсан байна.
- 2018 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 145,492 хүнд тусламж үйлчилгээ үзүүлж, үүнээс 7,174 хүнд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг амжилттай үзүүлсэн байна.
- Гемодиализийн нэгжийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэн 2018 онд байнга 13-14 үйлчлүүлэгчид 2 ээлжээр 1,062 сеанс эмчилгээ хийжээ. Мөн яаралтайгаар 7 хүнд бөөр орлуулах эмчилгээг 33 удаа хийсэн байна.
- Эрүүл мэндийн салбарын анхны эрүүл мэндийг дэмжигч төв болон нойрны төвтэй эмнэлэг болсон байна.
- Эмнэлэгтээ алсын зайн сургалтын телемедициний төвийг амжилттай байгуулж, үндэсний сүлжээнд холбогдсон байна.
- Эмнэлгийн үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 амжилттай нэвтрүүлж, түүнийг хэрэгжүүлэгч байгууллага болсон байна.
- Эмнэлгийн магадлан итгэмжлэлдээ амжилттай хамрагджээ.
- Өндөр хүчин чадал бүхий CT, MRI оношлогооны аппаратуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан байна. Цахилгааны нөөц эх үүсвэрийг ашиглалтанд оруулжээ.
- Эмнэлгийн 350 хүний суудалтай хурлын заал, спорт заал зэргийг бүрэн засварлаж үйл ажиллагаанд хэвийн оруулжээ.
- Health Promotion Center – Эрүүл мэндийг дэмжих төв – Метаболик синдром төвийн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

- Даатгалын тухай хууль
- Цэргийн албан хаагчийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирлын 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Б/08 дугаар тушаалаар бүтцийн өөрчлөлт хийсэн байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “UNICUS” програм хангамж ашигладаг байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 27 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.



Гүйцэтгэлийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг суурь үзүүлэлт болгон 2 хувиар тооцох нь зүйтэй гэж үзэв.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны нийт зардал 7,371,583.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 147,431.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг B201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг B401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 32 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

/Мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	23,720.0	
	Дүн	6	23,720.0	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд орууллаа.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус эмнэлгийн нийт ажилчин, албан хаагчдын цалингийн тулгалтыг цаг хугацааны боломжгүй байдлаас шалтгаалж хийж амжаагүй учир дараагийн аудитаар авч үзэх.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 10,453,736.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 10,452,239.4 мянган төгрөг буюу 1,497.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Үүнд:

Тус эмнэлгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар төсвийн гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 7,720,436.7 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 3,750,552.4 мянган төгрөг буюу 48,5 хувь, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 274,235.6 мянган төгрөг буюу 3,6 хувь, байр ашиглалттай холбоотой зардалд 230,115.7 мянган төгрөг буюу 3 хувь, хангамж бараа материалын зардалд 160,674.9 мянган төгрөг буюу 2 хувь, нормативт зардал /эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, зөөлөн эдлэл/-д 2,252,134.8 мянган төгрөг буюу 29,2 хувь, эд хогшил урсгал засварын зардалд 666,495.2 мянган төгрөг буюу 8,6 хувийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус эмнэлэг нь шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) портал сайтанд нийт оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 125 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 573 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явцын аудитаар тус эмнэлэг нь 4 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материал болгон хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын талаар**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тушаал шийдвэрийн батлагдсан төсөв алдаатай, анхан шатны баримтын бүрдэл дутуу 6,932.5 мянган төгрөг, техник хяналтын актгүй автомашины сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээнд 3,347.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Дэд бүтцийн сайдын 2014 оны 19 дүгээр тушаалаар баталсан 1 11 дүгээр хавсралтанд заасныг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3.2 Зардлын талаар**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Харилцахаас нийт 1,163.3 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн, шинэ жилийн баяраар хүүхдийн бэлгэнд 8,480.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, УИХ-ын 2016 оны 47 дугаар тушаалын 2-в-5-д заасныг тус тус зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах, ашиглан үүсэх,

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" мөн хуулийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", УИХ-ын 2016 оны 47 дугаар тушаалын 2-в-5-д "төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3.3 Зардлын талаар**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Нэр бүхий 2 компанитай хийсэн гэрээний дагуу санхүүжилт олгосон боловч гэрээнд заасан үнийн дүнгээс 727.6 мянган төгрөгөөр илүү бараа бүтээгдэхүүн авсан, мөн нэр бүхий 4 компанитай хийсэн гэрээг дүгнэсэн акт протокол байхгүй байна.

Энэ нь 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 2018/001/01 дугаартай гэрээ болон, 2018/001/02 дугаартай гэрээний хавсралтыг зөрчсөн байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Гэрээнд заасан хавсралтын дагуу бүтээгдэхүүн авах, илүү дутуу авсан талаар гэрээ дүгнэсэн актанд тусгаж байх, аливаа гэрээг дүгнэж акт протокол үйлдэж байх талаар зөвлөмж өгөх.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3.4 Бараа материалын талаар**

### **3.4.1 Илрүүлэлт:**

Нийт 2,130.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод дутуу авсан, програмд бараа материалын үлдэгдэл нэгж үнэ болон тоо ширхэгээр харагдахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.3, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1-д заасныг тус тус зөрчсөн байна.

#### **3.4.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх,

#### **3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд дараахь зарчмыг баримтална", 4.1.3-т "Бүртгэл, тайлангийн үзүүлэлт энгийн, тодорхой, ойлгомжтой байх" мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

#### **3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.5 Орлогын талаар**

#### **3.5.1 Илрүүлэлт:**

Улсын ерөнхий прокурорын газартай 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн УСҮ/18/02 дугаартай гэрээ хийж хавсралт 1-д үзлэг шинжилгээний багцын дүн 1 хүний 32.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Урьчилан сэргийлэх үзлэгийн тайланд нийт 29 ажилтан тус эмнэлэгт үзлэгт хамрагдсан боловч үзлэгийн 939.0 мянган төгрөгийг төлөөгүй, үзлэгийн төлбөрийг авлагаар бүртгэж тайлан тэнцэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1-д заасныг тус тус зөрчсөн байна.

#### **3.5.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх

#### **3.5.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг мөрдөж ажиллах мөн урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээний хавсралтын дагуу үзүүлэх ажилтан, албан хаагчид гүйцэтгэлээр дутуу үзүүлж байгааг үзлэгийн дүгнэлтэнд хугацаа зааж үзэх, үзэхгүй гэдгийг тодорхой болгох мөн нийт урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээний 2.5-д заасныг мөрдөж ажиллах дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж өгөх.

#### **3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.6 Шилэн дансны талаар**

#### **3.6.1 Илрүүлэлт:**

Тус эмнэлэг нь шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) портал сайтанд нийт оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 125 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, 4.1.3-т заасныг тус тус зөрчсөн байна.

#### **3.6.2 Эрсдэл:**

Шилэн дансны мэдээлэл үнэн, зөв нээлттэй бус байх,

#### **3.6.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

#### **3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,804,153,939.25</u></b>	<b><u>3,272,412,449.72</u></b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	527,404,589.00	547,129,415.00
Кассанд байгаа бэлэн мөнгө	10,370.00	-
Төгрөг	10,370.00	
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	527,394,219.00	547,129,415.00
<b>Төгрөг</b>	527,394,219.00	547,129,415.00
